

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шивээ-Овоо ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/40/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261668 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Лхагвацэнд

Утас: 261885 Цахим хаяг: Lkhagvatsendb@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Мягмаржав

Утас: 263533 Цахим хаяг: myagmarjagt@audit.gov.mn

Юнистар аудит ХХК

Захирал: М.Энхжаргал

Утас: 11-328735 Цахим хаяг: info@unistaraudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ШИВЭЭ-ОВОО ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Ц.ЭНХТҮВШИН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/758
танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шивээ-Овоо ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шивээ-Овоо ХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Шивээ овоо ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө 1,341.9 сая төгрөг, хуримтлагдсан алдагдал 77,614.5 сая төгрөг, эзэмшигчдийн өмч -76.272.6 сая төгрөг байна. Алдагдлын гол шалтгаан нь тус компанийн зорилтот түвшний төлөвлөгөөгөөр 1 төгрөгийн борлуулалтанд 1.29 төгрөгийн зардал гаргахаар төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 1.14 төгрөгийн зардал гаргаж, зардлын түвшинг 0.15 функтээр бууруулсан байна.

Аудитын гол асуудал

Шивээ-Овоо ХК-ийн бүх гишүүдийн 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 02 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийг томилсон байна. Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 онд гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулаагүй, 2023 оны ажлыг үнэлээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Шивээ-Овоо ХК нь тайлант оны бизнес төлөвлөгөөгөөр 2,295.0 мянган тонн нүүрс олборлон, борлуулахаар анх төлөвлөсөн бол Улаанбаатар хотын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 220.0 мянган тонн нүүрс нэмж тодотгол хийгдсэн байна. Нүүрс борлуулалтын хэмжээ өнгөрсөн оноос 295.2 мянган тонноор нэмэгдсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12 дугаар сарын 31	2023оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,117,546,840.86	2,723,457,186.71
1.1.2	Дансны авлага	2,705,814,206.76	3,668,041,491.15
1.1.4	Бусад авлага	652,524,207.21	368,054,187.29
1.1.6	Бараа материал	23,289,931,157.00	25,112,107,392.26
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	5,240,216,434.53	398,196,862.13
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	33,006,032,846.36	32,269,857,119.54
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	56,810,770,415.75	59,426,400,832.00
1.2.2	Биет бус хөрөнгө	189,628,430.36	155,223,197.03
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	31,613,207,659.21	-
1.2.7	Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	627,169,395.40	627,169,395.40
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	50,858,534.26	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	89,291,634,434.98	60,208,793,424.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	122,297,667,281.34	92,478,650,543.97
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	27,986,318,639.56	47,194,259,072.28
2.1.1.2	Цалингийн өглөг	2,779,504,418.00	1,400,043,367.00
2.1.1.3	Татварын өр	10,389,537,355.12	12,575,872,985.43
2.1.1.4	НДШ - ийн өглөг	5,603,144,194.38	7,300,612,233.14
2.1.1.5	Богино хугацаат зээл	2,700,000,000.00	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	13,041,910.10	13,041,910.10
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	11,020,178.92	9,262,188.26
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	8,516,228,701.96	8,908,080,517.37
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	57,998,795,398.04	77,401,172,273.58
2.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2	Урт хугацаат зээл	12,022,480,990.70	12,092,784,127.05
2.1.2.2	Засгийн газрын дэмжлэг	68,358,188,635.80	67,708,005,502.98
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр / Санхүүгийн түрээсийн өглөг	15,244,557,037.37	11,498,020,037.38
2.1.2.5	Ажилчдын тэтгэврийн сан	104,860,000.00	51,255,726.00
2.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	95,730,086,663.87	91,350,065,393.41
2.2	Өр төлбөрийн нийт дүн	153,728,882,061.91	168,751,237,666.99
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,207,710,000.00	1,207,710,000.00
2.3.2	- хувийн	134,190,000.00	134,190,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(32,773,114,780.57)	(77,614,487,123.02)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(31,431,214,780.57)	(76,272,587,123.02)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	122,297,667,281.34	92,478,650,543.97

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	2023оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	67,062,911,760.70	96,286,302,345.44
2	Борлуулалтын өртөг	79,287,983,595.10	102,134,404,117.07
3	Нийт ашиг (алдагдал)	(12,225,071,834.40)	(5,848,101,771.63)
5	Хүүний орлого	-	9,965,649.99
8	Бусад орлого	387,565,794.83	132,606,618.87
9	Борлуулалт, маркетингийн зардал	18,932,954.09	1,752,837,714.46
10	Ерөнхий ба удирдлагын зардал	994,071,819.98	1,057,189,662.98
11	Санхүүгийн зардал	655,918,508.96	1,708,362,320.50
12	Бусад зардал	5,424,706,282.57	1,563,043,537.03
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	67,327,459.20	747,940,129.94
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(100,232,240.60)	4,857,052.81
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(18,964,040,386.58)	(11,034,165,555.00)
19	Орлогын татварын зардал	1,545,346.58	1,353,058.24
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(18,965,585,733.16)	(11,035,518,613.24)
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(18,965,585,733.16)	(11,035,518,613.24)
24	Орлогын нийт дүн	(18,965,585,733.16)	(11,035,518,613.24)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 дугаар сарын 31	/төгрөгөөр/ 2023оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	79,448,039,835.04	114,947,397,165.07
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	70,369,069,469.34	100,932,189,764.21
1.1.6	Бусад мөнгөн орлого	9,078,970,365.75	14,015,207,400.87
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	73,850,060,629.83	96,236,660,797.68
1.2.1	Ажиллагчдад төлсөн	9,889,894,034.00	14,746,927,602.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	3,646,000,000.00	2,861,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	21,890,841,421.35	28,703,637,734.11
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	28,702,504,204.88	37,328,292,900.07
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	334,337,614.88	249,456,589.61
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	2,915,467,586.45	3,228,974,270.62
1.2.9	Бусад мөнгөн зарлага	6,471,015,768.27	9,118,371,701.27
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,597,979,205.26	18,710,736,367.39
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,005,328,163.62	10,741,117,127.43
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,264,261,076.35	10,618,578,058.60
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	2,741,067,087.27	122,539,068.83
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,005,328,163.62)	(10,741,117,127.43)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	5,000,197,000.00	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	5,000,197,000.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,884,715,058.85	6,363,708,894.11
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	4,771,180,870.00	3,017,364,274.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	900,000,000.00	3,180,000,000.00
3.2.6	Буцалтгүй тусламж	213,534,188.85	166,344,620.11
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(884,518,058.85)	(6,363,708,894.11)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	708,132,982.79	1,605,910,345.85
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	409,413,858.07	1,117,546,840.86
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,117,546,840.86	2,723,457,186.71

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(14,428,293,205.97)	(13,086,393,205.97)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	620,764,158.56	620,764,158.56
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	(13,807,529,047.41)	(12,465,629,047.41)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(18,965,585,733.16)	(18,965,585,733.16)
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(32,773,114,780.57)	(31,431,214,780.57)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(33,805,853,729.21)	(33,805,853,729.21)
Залруулсан үлдэгдэл	1,341,900,000.00	(66,578,968,509.78)	(65,237,068,509.78)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	(11,035,518,613.24)	(11,035,518,613.24)
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,341,900,000.00	(77,614,487,123.02)	(76,272,587,123.02)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтү үд	Хэмжи х нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
				төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү	Хувь
А	Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт						
1	Нүүрс олборлолт	м.тн	2,169.1	2,515.0	2,479.1	(35.9)	98.6
2	Нүүрс борлуулалт	м.тн	2,182.3	2,515.0	2,477.5	(37.5)	98.5
6	Нийт хөрс хуулалт	м.м³	9,173.1	10,447.0	10,097.8	(349.2)	96.7
8	Нийт уулын цул	м.м³	14,858.0	17,400.7	16,186.7	(1,214.0)	93.0
Б	Орлого, зардал, ашгийн үзүүлэлт						
1	Борлуулалтын орлого	мян.төг	67,062,911.8	98,159,795.4	96,286,302.3	(1,873,493.1)	98.1
2	Үйл ажиллагааны бус орлого	мян.төг	454,893.3	67,000.0	895,369.5	828,369.5	1,336.4
2.1	Ханшийн зөрүүний олз	мян.төг	67,327.5		747,940.1	747,940.1	-
2.2	Бусад орлого	мян.төг	281,897.3	57,000.0	121,218.3	64,218.3	212.7
2.3	Хүү торгууль, алдангийн орлого	мян.төг	102,765.6	10,000.0	5,432.7	(4,567.3)	54.3
2.5	Даатгалын орлого	мян.төг	2,902.9		5,955.6	5,955.6	-
2.6	Хүүний орлого	мян.төг			9,965.6	9,965.6	-
2.7	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	мян.төг			4,857.1	4,857.1	-
3	Нийт орлого	мян.төг	67,517,805.0	98,226,795.4	97,181,671.8	(1,045,123.6)	98.9
4	Үйлдвэрлэлийн зардал	мян.төг	80,956,906.9	123,084,026.7	106,652,793.8	(16,431,232.9)	86.7
4.1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	мян.төг	79,287,983.6	120,005,029.3	102,134,404.1	(17,870,625.2)	85.1

4.2	Борлуулалт маркетингийн зардал	мян.төг	18,933.0	715,928.5	1,752,837.7	1,036,909.2	244.8
4.3	Ерөнхий удирдлагын зардал	мян.төг	994,071.8	1,498,308.8	1,057,189.7	(441,119.2)	70.6
4.4	Санхүүгийн зардал	мян.төг	655,918.5	864,760.1	1,708,362.3	843,602.3	197.6
5	Үйл ажиллагааны бус зардал	мян.төг	5,524,938.5	2,004,638.3	1,563,043.5	(441,594.8)	78.0
6	Нийт зардал	мян.төг	86,481,845.4	125,088,665.0	108,215,837.3	(16,872,827.7)	86.5
7	Татварын өмнөх ашиг	мян.төг	(18,964,040.4)	(26,861,869.6)	(11,034,165.5)	15,827,704.1	41.1
8	Орлогын албан татвар	мян.төг	1,545.3	-	1,353.1	1,353.1	-
9	Татварын дараах алдагдал	мян.төг	(18,965,585.7)	(26,861,869.6)	(11,035,518.6)	15,826,351.0	41.1
В	Бусад үзүүлэлт						
1	1 тн нүүрсний дундаж өртөг	төг	39,870.8	49,822.3	43,651.8	(6,170.5)	87.6
2	1 тн нүүрсний дундаж үнэ	төг	30,730.9	39,029.7	38,864.7	(165.0)	99.6
3	1 м ³ уулын цулын өртөг	төг	5,599.6	7,260.0	6,763.7	(496.3)	93.2
4	Хөрс хуулалтын коэффициент	коэфф	4.23	4.15	4.07	(0.08)	98.1
5	Ажилчдын тоо	хүн	434.2	487.0	435.6	(51.4)	89.4
6	Нийт цалингийн сан	мян.төг	14,596,533.4	18,255,073.8	18,178,621.3	(76,452.6)	99.6
7	Нийт авлага	мян.төг	6,526,753.9	5,000,000.0	6,874,942.2	1,874,942.2	137.5
8	Нийт өглөг	мян.төг	153,728,882.1	153,728,800.0	168,751,237.7	15,022,437.7	109.8
8.1	Богино хугацаат өглөг	мян.төг	58,002,385.8	49,211,084.0	77,742,965.6	28,531,881.7	158.0
9	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал	төг	1.24	1.29	1.14	(0.15)	88.4
10	Төсвийн төлбөрт	мян.төг	11,125,762.7	13,213,360.7	12,704,720.3	(508,640.4)	96.2

10.1	Үүнээс: а\ ААН-ОАТ	мян.төг	1,545.3	-	1,353.1	1,353.1	-
10.2	б\ НӨАТ	мян.төг	6,706,291.2	9,815,979.5	9,628,630.2	(187,349.3)	98.1
10.3	в\ бусад татвар	мян.төг	2,741,353.4	3,397,381.2	3,074,737.0	(322,644.2)	90.5
10.4	г\ АМНАТ		1,676,572.8	2,453,994.9	2,407,157.6	(46,837.3)	98.1
12	Хөдөлмөрийн бүтээмж, орлогоор	мян.төг	155,499.3	201,697.7	223,098.4	21,400.7	110.6
13	Хөдөлмөрийн бүтээмж, ажлаар	м.м ³	34.2	35.7	37.2	1.4	104.0
14	Нөхөн сэргээлтийн зардал	мян.төг	39,223.6	52,000.0	45,156.0	(6,844.0)	86.8

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 34,000.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 34,000.7 сая төгрөгийн алдааг залруулав.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д / Д	Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
						Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Юнайтед белаз машинери ХХК-с 5 ширхэг белаз машиныг лизингийн гэрээгээр 2016-05-24-нд авсан. Лизингийн гэрээгээр 2016-12 сараас 2019 сарын 11 сарыг дуустал 48 сар төлбөрийг төлж дуусгана. Лизингийн зээлийн хүүгийн 2,192,646,070.00 төгрөгийн өглөгийг 2016-10-30-ны өдөр бүртгэхдээ нөгөө талд нь Урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэсэн. Дээрхи хугацаанд зээлийн хүүгийн зардлыг тайлант хугацаануудад хуваарилан бүртгээгүй.	1	2,192,646.1	1	2,192,646.1	1	2,192,646.1		
2	34,287,341,156.41 төгрөгийн хөрс хуулалтын зардлыг капиталжуулж эргэлтийн бус хөрөнгөөр бүртгэсэн байна. Мөн 2,674,133.497.20 төгрөгийн хойшлогдсон хөрс хуулалтын шавхагдал гэсэн сөрөг данс үүсгэж эргэлтийн бус хөрөнгөнд хасах дүнтэй бүртгэсэн байна. Хөрс хуулалтын дээрх зардлыг 2019 оноос хойш олборлосон нүүрсний өртөгт хувь тэнцүүлж хуваарилж бүртгээгүй байна.	1	31,613,207.6	1	31,613,207.6	1	31,613,207.6		

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

3	Хөрс тээврийн ажил гүйцэтгэх гэрээтэй Пүүл ресурс ХХК-ийн ажилчдын хоолны тооцоо 194,857,590.90 төгрөгийг үйл ажиллагааны бус зардлаар бүртгэсэн байна.	1	194,857.6	1	194,857.6	1	194,857.6		
Дүн		3	34,000,711.3	3	34,000,711.3	3	34,000,711.3	-	-

Аудитаар нийт 397.6 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 2.2 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 217.8 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага, 177.6 сая төгрөгийн зөрчилд, зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлэв.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн
1	Анхан шатны баримтад эрх бүхий албан тушаалтан, гүйцэтгэх захирлаар гарын үсэг зуруулж баталгаажуулалгүй 147,057,878.00 төгрөгийн кассын зарлага гаргаж, худалдан авалт хийсэн байна.	1	147,057.8			1	147,057.8		
2	Өмнөх аудитаар өгсөн, бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна. Ижил төрлийн 217.8 сая төгрөгийн хангамжийн материалыг шууд худалдан авах үнийн хязгаарт багтааж задлан 13 гэрээгээр худалдан авсан. Худалдан авах ажиллагааг хуульд нийцүүлээгүй	1	217,800.1			1	217,800.1		

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

	зөрчлийг давтан гаргасан.								
3	Албан томилолтыг захирлын тушаал, удирдамжгүй, томилолтын хуудсаар олгосон. Томилолтын тайлан илтгэх хуудас зэрэг дэмжих нотлох баримт хангалтгүй байна.	1	30,502.9			1	30,502.9		
4	Компанийн дотоод журмын дагуу ажиллагсад олгосон 19,300,000.00 төгрөгийн буцалтгүй тусламж, 3,195,000.00 төгрөгийн сувиллын хөнгөлөлтөөс ХХОАТ суутгаж, төсөвт төлөөгүй.	1	2,249.5	1	2,249.5				
Дүн		4	397,610.3	1	2,249.5	3	365,360.8		

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Худалдан авах ажиллагаанд хэрэгжүүлсэн аудитын горим сорилын үр дүнд ижил төрлийн 217.8 сая төгрөгийн хангамжийн материалыг шууд худалдан авах үнийн хязгаарт багтааж задлан 13 гэрээгээр худалдан авсан зөрчил илэрсэн. Энэхүү зөрчлийг өмнөх аудитаар илрүүлж албан шаардлага өгсөн байсан ба энэ зөрчилд авах хариу арга хэмжээг энэ тайлангийн 4.5.2-т дурдсан болно

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцсэн, харин худалдан авах ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцээгүй гэж дүгнэлээ.